

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/280/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он	Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261665 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: А.Цогбаяр Утас: 260512 Цахим хаяг: tsogbayara@audit.gov.mn Ахлах аудитор: Ж.Бүжинханд Утас: 261628 Цахим хаяг: bujinkhandj@audit.gov.mn “Ариун төгс оршихуй аудит” ХХК-ийн захирал: Г.Баялаг Утас: 99023656 Цахим хаяг: ariuntugsorshihuaudit@gmail.com
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан.....
 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС

Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 06/284
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 13,673,311.9 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа болон нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны 283 дугаар тогтоолын дагуу анхны өртгөө нөхсөн 7,545,283.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг данснаас хасалт хийгээгүй, дансны үнийг шинэчлэн тогтоосон 5,134,736.0 мянган төгрөгийн хөрөнгийг орлого авахдаа хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү дансанд буруу бүртгэж тайлагнасан;
- Барилга, байгууламжид хийгдсэн их засварын ажлыг капиталжуулахдаа 282,683.2 мянган төгрөгөөр дутуу бүртгэсэн;
- Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үндсэн үйл ажиллагааны орлогын дүн нь сорьцын шинжилгээний "Лимис" программын орлогын дүнгээс 182,794.9 мянган төгрөгөөр илүү тусгасан;
- Үндсэн хөрөнгийн бүртгэлд 56,571.8 мянган төгрөгийн өртөг бүхий 17 нэр төрлийн 32 хөрөнгөнд тайлант хугацаанд элэгдлийн зардлыг тооцоогүй;

- Тайлант хугацаанд харилцагч байгууллагуудаас авах 19,503.0 мянган төгрөгийн авлагын, бэлтгэн нийлүүлэгч байгууллагад төлөх 89,760.3 мянган төгрөгийн өр төлбөрийн үлдэгдлийг тус тус тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй;
- Бараа материалын дансанд оны эхнээс огт хөдөлгөөн ороогүй 59,653.7 мянган төгрөгийн үнийн дүнтэй эм урвалжийн материалыг нөөцөлсөн зэрэг зөрчлүүд илэрсэн.

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5, 6.4.8, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.5, 20.2.6 дахь заалтуудтай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлангийн “иж бүрэн байх”, “эрх ба үүрэг” “зохистой буюу нийцсэн байх” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Нэмэлт санхүүжилтийн дансанд Нэгдсэн үндэсний байгууллагын Хүнс, хөдөө аж ахуйн газраас 14,468.8 мянган төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 22,058.0 мянган төгрөг, нийт 36,526.8 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, 14,412.5 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 22,114.3 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлжээ.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2025 оны А/223, А/247, А/298, А/302, А/305, А/343, А/326, А/375 тоот тушаалуудын дагуу 2,849,365.0 мянган төгрөгийн, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2025 оны №А-1/21025 албан тоотоор 41,837.3 мянган төгрөгийн хөрөнгө, нийт 2,891,202.3 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй шилжиж ирснийг санхүүгийн тайланд тусгажээ.

Бусад асуудлын хэсэг

Лабораторийн чанарын хяналтын төлөвлөгөөний дагуу нийт 19 лабораторитай хамтран ажиллах гэрээ байгуулж, үндэсний 75 лаборатори хоорондын харьцуулсан шинжилгээ, олон улсын ур чадварын сорилтод 5 удаа оролцохоор тус тус төлөвлөснөөс биелэлт нь 100 хувьтай байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын зүйл	Тодруулга	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		403,884,423.22	591,266,635.20
33	АВЛАГА		8,839,077.94	253,616,478.13
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага		-	35,923.13
33300	Татаас, санхүүжилтийн авлага		-	234,113,405.30
33402	Татвар, НДШ – ийн авлага /ТӨҮГ/		2,531,577.94	-
335	Бусад авлага		6,307,500.00	19,467,150.00
3351	Байгууллагаас авах авлага		6,307,500.00	19,467,150.00
35	БАРАА МАТЕРИАЛ		395,045,345.28	337,650,157.07
351	Түүхий эд материал		180,496,183.31	153,206,054.46
35130	Эм боох материал		180,496,183.31	153,206,054.46
354	Хангамжийн материал		214,549,161.97	184,444,102.61
35410	Бичиг хэргийн материал		4,858,024.49	8,611,270.00
35420	Аж ахуйн материал		62,557,007.15	55,738,287.71
35430	Сэлбэг хэрэгсэл		19,142,400.00	11,691,000.00
35440	Түлш, шатах тослох материал		2,152,341.47	11,628.62
35460	Хүнсний материал		410,400.00	-
35470	Бусад хангамжийн материал		84,324,480.59	72,222,120.59
35500	Биологийн хөрөнгө		41,104,508.27	36,169,795.69
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		11,905,609,141.56	17,344,064,410.40
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ		11,905,609,141.56	17,344,064,410.40
392	Биет хөрөнгө		11,687,530,114.01	17,138,938,122.65
39201	Барилга, байгууламж, орон сууц		12,116,443,415.71	13,323,673,132.71
39202	Хуримтлагдсан элэгдэл		(2,275,982,386.31)	(2,476,577,490.79)
39203	Авто-тээврийн хэрэгсэл		29,950,000.00	71,787,273.25
39204	Хуримтлагдсан элэгдэл		(29,950,000.00)	(30,885,657.94)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)		8,873,876,621.45	14,949,296,162.38
39206	Хуримтлагдсан элэгдэл		(7,092,191,483.64)	(9,210,892,606.82)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил		970,386,151.18	1,696,890,236.63
39208	Хуримтлагдсан элэгдэл		(945,417,454.84)	(1,223,937,696.67)
39214	Бусад үндсэн хөрөнгө		50,170,000.00	50,170,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл		(9,754,749.54)	(10,585,230.10)
393	Биет бус хөрөнгө		218,079,027.55	205,126,287.75
39301	Програм хангамж		1,359,800.00	1,359,800.00
39302	Хуримтлагдсан элэгдэл		(1,359,800.00)	(1,359,800.00)
39303	Бусад биет бус хөрөнгө		283,590,000.00	283,590,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл		(65,510,972.45)	(78,463,712.25)
3	НИИТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		12,309,493,564.78	17,935,331,045.60
4	НИИТ ӨР ТӨЛБӨР		458,700.00	123,368,385.74
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		458,700.00	123,368,385.74
413	Өглөг		458,700.00	123,368,385.74
41310	Ажилчидтай холбогдсон өглөг		-	2,768,255.93
4136	Бусад өглөг		458,700.00	120,600,129.81
41361	Байгууллагад төлөх өглөг		458,700.00	120,600,129.81
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		12,309,034,864.78	17,811,962,659.86
51	Засгийн газрын хувь оролцоо		12,309,034,864.78	17,811,962,659.86
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		2,560,500,816.70	2,560,500,816.70
51101	Өмч: - төрийн		2,560,500,816.70	2,560,500,816.70
512	Хуримтлагдсан үр дүн		9,672,958,641.55	10,041,150,460.55
51210	Өмнөх үеийн үр дүн		8,369,748,369.33	9,672,958,641.55
51220	Тайлант үеийн үр дүн		1,303,210,272.22	368,191,818.70
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		75,575,406.53	5,210,311,382.91

6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		12,309,493,564.78	17,935,331,045.60
---	--	--	-------------------	-------------------

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Тодруулга	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН		5,499,155,917.99	7,186,741,790.55
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		2,855,323,277.99	7,186,741,790.55
120	Нийтлэг татварын бус орлого		2,855,323,277.99	4,612,480,574.55
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого		1,347,422,887.56	1,700,253,274.30
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		1,328,868,672.00	1,700,253,274.30
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого		18,554,215.56	-
120009	Бусад орлого		11,175,390.43	21,025,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө		1,496,725,000.00	2,891,202,300.25
122	Тусламжийн орлого		-	2,574,261,216.00
1221	Хандив тусламж /дотоод/		-	2,574,261,216.00
12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого		-	2,537,040,300.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого\		-	2,537,040,300.00
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого		-	37,220,916.00
122131	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		-	14,468,750.00
122135	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		-	22,752,166.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		2,643,832,640.00	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс		2,136,613,800.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		2,136,613,800.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		507,218,840.00	-
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		30,500,000.00	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		10,731,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		35,000,000.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		430,987,840.00	-
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН		4,195,945,645.77	6,818,549,971.85
21	УРСГАЛ ЗАРДАЛ		4,195,945,645.77	6,818,549,971.85
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		3,636,680,492.63	6,727,659,751.51
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		2,363,631,000.00	3,070,540,790.15
210101	Үндсэн цалин		1,462,493,000.00	1,710,294,973.48
210102	Нэмэгдэл		483,221,139.75	629,510,984.78
210103	Унаа хоолны хөнгөлөлт		261,333,896.96	461,412,258.08
210104	Урамшуулал		156,582,963.29	269,322,573.81
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		329,983,545.70	388,185,506.51
210201	Тэтгэврийн даатгалын зардал		243,368,245.70	263,425,106.51
210202	Тэтгэмжийн даатгалын зардал		15,706,300.00	31,190,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал		7,852,800.00	15,595,100.00
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал		11,818,200.00	15,595,100.00
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал		51,238,000.00	62,380,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		113,146,959.98	147,826,536.60
210301	Гэрэл, цахилгаан		56,718,534.80	87,285,928.12
210302	Түлш, халаалт		37,088,962.64	38,548,364.33
210303	Цэвэр, бохир ус		19,339,462.54	21,992,244.15
2104	Хангамж, бараа материалын зардал		77,264,754.95	80,688,328.83

210401	Бичиг хэрэг		19,469,458.61	52,372,462.58
210402	Тээвэр, шатахуун		8,606,218.65	11,105,139.72
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		5,769,258.01	5,633,683.58
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		1,845,500.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		40,614,319.68	11,577,042.95
210409	Бараа материал шилжүүлсний зардал		960,000.00	-
2105	Нормативт зардал		233,776,532.63	273,454,398.43
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		218,784,489.63	261,960,606.43
210502	Хоол, хүнс		14,447,543.00	11,493,792.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		544,500.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		35,128,666.66	48,502,040.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		12,212,096.66	26,451,140.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		5,763,000.00	17,932,900.00
210604	Урсгал засвар		17,153,570.00	4,118,000.00
2107	Томилолт, зочны зардал		10,711,500.00	3,666,800.00
210702	Дотоод албан томилолт		10,711,500.00	3,666,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		74,647,823.66	38,246,245.84
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		29,447,860.66	2,661,245.84
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		6,000,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ		989,100.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар		59,984.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		37,414,778.00	35,585,000.00
210807	Газрын төлбөр		238,601.00	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх		497,500.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		398,389,709.05	2,676,549,105.15
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		6,043,813.64	61,713,757.36
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		20,500,100.00	2,300,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол		371,845,795.41	2,612,535,347.79
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		559,265,153.14	90,890,220.34
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг		-	54,372,278.48
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг		-	54,372,278.48
213112	Төсвийн байгууллагаас харъяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал		-	54,372,278.48
2131121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал\		-	51,691,028.48
2131123	Нэмэлт санхүүжилтийн дансны төсвийн орлогод тооцох төвлөрүүлгийн зардал\		-	2,681,250.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		180,382,061.33	36,517,941.86
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		24,393,709.33	35,217,941.86
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		155,988,352.00	1,300,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг		378,883,091.81	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		334,816,682.81	-
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		44,066,409.00	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		1,303,210,272.22	368,191,818.70
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)		1,303,210,272.22	368,191,818.70

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Тодруулга	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН		3,972,701,312.00	4,288,247,455.30
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		1,328,868,672.00	4,288,247,455.30
120	Нийтлэг татварын бус орлого		1,328,868,672.00	1,714,680,405.30
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого		1,328,868,672.00	1,714,680,405.30

1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		1,328,868,672.00	1,714,680,405.30
122	Тусламжийн орлого		-	2,573,567,050.00
1221	Хандив тусламж /дотоод/		-	2,573,567,050.00
12211	Харьяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого		-	2,537,040,300.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого\		-	2,537,040,300.00
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого		-	36,526,750.00
122131	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		-	14,468,750.00
122135	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		-	22,058,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		2,643,832,640.00	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс		2,136,613,800.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		2,136,613,800.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		507,218,840.00	-
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		30,500,000.00	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		10,731,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		35,000,000.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		430,987,840.00	-
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		3,875,451,642.00	4,263,195,115.30
21	УРСГАЛ ЗАРДАЛ		3,875,451,642.00	4,263,195,115.30
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		3,314,258,488.86	3,939,491,489.96
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		2,363,631,000.00	3,058,173,321.34
210101	Үндсэн цалин		1,462,493,000.00	1,697,927,504.67
210102	Нэмэгдэл		483,221,139.75	629,510,984.78
210103	Унаа хоолны хөнгөлөлт		261,333,896.96	461,412,258.08
210104	Урамшуулал		156,582,963.29	269,322,573.81
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		327,647,233.21	385,650,748.64
210201	Тэтгэврийн даатгалын зардал		233,101,933.21	260,890,348.64
210202	Тэтгэмжийн даатгалын зардал		23,636,300.00	31,190,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал		11,818,200.00	15,595,100.00
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал		11,818,200.00	15,595,100.00
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал		47,272,600.00	62,380,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		113,146,959.98	147,826,536.60
210301	Гэрэл, цахилгаан		58,357,917.24	87,285,928.12
210302	Түлш, халаалт		35,526,000.00	38,548,364.33
210303	Цэвэр, бохир ус		19,263,042.74	21,992,244.15
2104	Хангамж, бараа материалын зардал		52,148,458.01	36,797,304.58
210401	Бичиг хэрэг		18,132,558.00	13,563,700.00
210402	Тээвэр, шатахуун		9,861,790.00	7,500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		5,769,258.01	4,805,978.58
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		1,845,500.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		16,539,352.00	10,927,626.00
2105	Нормативт зардал		266,465,872.00	173,706,500.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		250,246,429.00	161,520,780.00
210502	Хоол, хүнс		14,857,943.00	12,185,720.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		1,361,500.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		85,528,470.00	11,871,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		5,700,900.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		40,988,000.00	1,716,600.00
210604	Урсгал засвар		38,839,570.00	10,155,000.00
2107	Томиллолт, зочны зардал		10,711,500.00	3,666,800.00
210702	Дотоод албан томиллолт		10,711,500.00	3,666,800.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		70,428,895.66	47,449,245.84
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		27,343,832.66	32,412,745.84
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		3,867,800.00	-
210803	Даатгалын үйлчилгээ		989,100.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар		59,984.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		37,432,078.00	14,886,400.00
210807	Газрын төлбөр		238,601.00	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх		497,500.00	150,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		24,550,100.00	74,349,432.96
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		-	72,049,432.96
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		24,550,100.00	2,300,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		561,193,153.14	323,703,625.34
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг		-	288,485,683.48
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг		-	288,485,683.48
213112	Төсвийн байгууллагаас харъяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал		-	288,485,683.48
2131121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал\		-	51,691,028.48
2131123	Нэмэлт санхүүжилтийн дансны төсвийн орлогод тооцох төвлөрүүлгийн зардал		-	2,681,250.00
2131125	Төсвийн дансны авлагад тооцох төвлөрүүлэх шилжүүлгийн зардал		-	214,680,405.00
2131126	Нэмэлт санхүүжилтийн дансны авлагад тооцох төвлөрүүлэх шилжүүлгийн зардал		-	19,433,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		182,310,061.33	35,217,941.86
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		24,393,709.33	35,217,941.86
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		157,916,352.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг		378,883,091.81	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		334,816,682.81	-
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		44,066,409.00	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)		97,249,670.00	25,052,340.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН		97,249,670.00	25,052,340.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		97,249,670.00	25,052,340.00
2200	Дотоод эх үүсвэрээр		97,249,670.00	25,052,340.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		97,249,670.00	25,052,340.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)		(97,249,670.00)	(25,052,340.00)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)		-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-	-
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,560,500,816.70	75,575,406.53	8,369,748,369.33	11,005,824,592.56
9	Тайлант үеийн үр дүн	-	-	1,303,210,272.22	1,303,210,272.22
10	2024 оны 12-р сарын 31-	2,560,500,816.70	75,575,406.53	9,672,958,641.55	12,309,034,864.78

	нээрх үлдэгдэл				
13	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	5,134,735,976.38	-	5,134,735,976.38
19	Тайлант үеийн үр дүн	-	-	368,191,818.70	368,191,818.70
20	2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	2,560,500,816.70	5,210,311,382.91	10,041,150,460.25	17,811,962,659.86

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	4,037,115,100.00	3,958,349,271.82	78,765,828.18	98.0
12	Татварын бус орлого	4,037,115,100.00	3,958,349,271.82	78,765,828.18	98.0
120	Нийтлэг татварын бус орлого	1,500,000,000.00	1,714,680,405.30	(214,680,405.30)	114.3
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	1,500,000,000.00	1,714,680,405.30	(214,680,405.30)	114.3
122	Тусламжийн орлого	2,537,115,100.00	2,243,668,866.52	293,446,233.48	88.4
122005	Төсвөөс санхүүжих	2,537,115,100.00	2,243,668,866.52	293,446,233.48	88.4
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,037,115,100.00	3,985,349,271.82	51,765,828.18	98.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,037,115,100.00	3,985,349,271.82	51,765,828.18	98.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,001,052,000.00	3,950,131,329.96	50,920,670.04	98.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,073,734,500.00	3,047,773,321.34	25,961,178.66	99.2
210101	Үндсэн цалин	1,695,832,200.00	1,697,927,504.67	(2,095,304.67)	100.1
210102	Нэмэгдэл	621,512,600.00	629,510,984.78	(7,998,384.78)	101.3
210103	Унаа хоолны хөнгөлөлт	472,393,500.00	461,412,258.08	10,981,241.92	97.7
210104	Урамшуулал	283,996,200.00	258,922,573.81	25,073,626.19	91.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	386,858,500.00	385,650,748.64	1,207,751.36	99.7
210201	Тэтгэврийн даатгал	262,098,100.00	260,890,348.64	1,207,751.36	99.5
210202	Тэтгэмжийн даатгал	31,190,100.00	31,190,100.00	-	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	15,595,100.00	15,595,100.00	-	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	15,595,100.00	15,595,100.00	-	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	62,380,100.00	62,380,100.00	-	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	148,458,400.00	147,826,536.60	631,863.40	99.6
210301	Гэрэл, цахилгаан	62,267,900.00	87,285,928.12	(25,018,028.12)	140.2
210302	Түлш, халаалт	57,603,900.00	38,548,364.33	19,055,535.67	66.9
210303	Цэвэр, бохир ус	28,586,600.00	21,992,244.15	6,594,355.85	76.9
2104	Хангамж, бараа материалын зардал	35,003,200.00	34,284,924.58	718,275.42	97.9
210401	Бичиг хэрэг	9,808,400.00	13,251,320.00	(3,442,920.00)	135.1
210402	Тээвэр, шатахуун	6,881,300.00	5,300,000.00	1,581,300.00	77.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,285,100.00	4,805,978.58	479,121.42	90.9
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	757,700.00	-	757,700.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	12,270,700.00	10,927,626.00	1,343,074.00	89.1
2105	Нормативт зардал	184,166,100.00	179,606,630.00	4,559,470.00	97.5
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	170,359,700.00	168,921,030.00	1,438,670.00	99.2
210502	Хоол, хүнс	12,586,200.00	10,685,600.00	1,900,600.00	84.9
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,220,200.00	-	1,220,200.00	-

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	21,417,800.00	19,475,190.00	1,942,610.00	90.9
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,425,600.00	5,425,590.00	10.00	100.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,462,700.00	1,716,600.00	1,746,100.00	49.6
210604	Урсгал засвар	12,529,500.00	12,333,000.00	196,500.00	98.4
2107	Томилолт, зочны зардал	7,000,000.00	3,666,800.00	3,333,200.00	52.4
210702	Дотоод албан томилолт	7,000,000.00	3,666,800.00	3,333,200.00	52.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	70,063,100.00	57,497,745.84	12,565,354.16	82.1
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	42,536,100.00	42,461,245.84	74,854.16	99.8
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,465,100.00	-	3,465,100.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	1,378,000.00	-	1,378,000.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	59,700.00	-	59,700.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	19,900.00	-	19,900.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	21,372,800.00	14,886,400.00	6,486,400.00	69.7
210807	Газрын төлбөр	733,300.00	-	733,300.00	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	498,200.00	150,100.00	348,100.00	30.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	74,350,400.00	74,349,432.96	967.04	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	72,050,400.00	72,049,432.96	967.04	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,300,000.00	2,300,000.00	-	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	36,063,100.00	35,217,941.86	845,158.14	97.7
2132	Бусад урсгал шилжүүлэг	36,063,100.00	35,217,941.86	845,158.14	97.7
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	36,063,100.00	35,217,941.86	845,158.14	97.7
8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-	-	-	-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	130.0	104.0	-	80.0
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.0	1.0	-	100.0
610001	Төсвийн байгууллага	1.0	1.0	-	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	101.0	101.0	-	100.0
620001	Удирдах ажилтан	4.0	4.0	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	74.0	74.0	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	23.0	23.0	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН		36,526,750.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		36,526,750.00
122	Тусламжийн орлого		36,526,750.00
1221	Хандив тусламж /дотоод/		36,526,750.00
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого		36,526,750.00
350011	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		14,468,750.00
350015	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		22,058,000.00
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		14,412,500.00

21	УРСГАЛ ЗАРДАЛ		14,412,500.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		14,412,500.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		10,400,000.00
210104	Урамшуулал		10,400,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал		2,512,380.00
210401	Бичиг хэрэг		312,380.00
210402	Тээвэр, шатахуун		2,200,000.00
2105	Нормативт зардал		1,500,120.00
210502	Хоол, хүнс		1,500,120.00
4	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ		22,114,250.00
5	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		(22,114,250.00)
6	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт		(22,114,250.00)

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори нь лабораторийн шинжилгээний мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, хүнсний аюулгүй байдлын тандалт судалгаа, эрсдэлийн үнэлгээ хийх, шинжилгээний ур чадварыг үнэлэх сорилтыг зохион байгуулахыг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.

Дээрх чиг үүргийн дагуу Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори нь дотоодын болон экспорт, импортын бүх төрлийн хүнс, эм био бэлдмэл, гоо сайхан, ахуйн химийн бүтээгдэхүүн, хөрс, ус, таримал ургамлын үрийн чанарт эрүүл ахуйн аюулгүйн үзүүлэлтүүд болох нян, хөгц, мөөгөнцөр, тэдгээрийн гаралтай хор, химийн бодисын үлдэгдэл, ургамлын гадаад, дотоод хорио цээртэй хөнөөлт шавж, ургамлын өвчин, хог ургамлын үр, цацрагийн бохирдлыг тодорхойлох сорилт, шинжилгээг батлагдсан арга аргачлалын дагуу гүйцэтгэх үйл ажиллагааг явуулж байна.

Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори нь үндэсний болон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн магадлан итгэмжлэгдсэн лаборатори юм.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори нь Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль, Хэмжил зүйн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төсвийн хэмнэлтийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хуулийг үйл ажиллагаандаа мөрдөн ажилладаг.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.5 дахь заалт;
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2, 15 дугаар зүйлийн 15.1.8, 15.2.7 дахь заалт;
- Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”;

Удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори нь “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-т өөрчлөлт оруулж, шинэчилсэн нь үйл ажиллагааны онцлог болон холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэжээ.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 5,625,837.5 мянган төгрөгөөр буюу 45.7 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган
төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	8,839.1	253,616.4	244,777.3
Бараа материал	395,045.3	337,650.2	(57,395.1)
Үндсэн хөрөнгө	11,905,609.1	17,344,064.4	5,438,455.3
Нийт хөрөнгө	12,309,493.5	17,935,331.0	5,625,837.5
Өр төлбөр	458.7	123,368.4	122,909.7
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	12,309,034.8	17,811,962.6	5,502,927.8
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	12,309,493.5	17,935,331.0	5,625,837.5

Дээрх хүснэгтээс харахад, нөлөө бүхий өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өглөг, засгийн газрын хувь оролцоо данснууд байна. Тухайлбал:

- Авлагын дансны үлдэгдэл 253,616.4 мянган төгрөг болж, 244,777.3 мянган төгрөгөөр өссөн нь татаас санхүүжилтийн авлага 234,113.4 мянган төгрөгийн, ажилчидтай холбоотой 35.9 мянган төгрөгийн, байгууллагаас авах 19,467.1 мянган төгрөгийн авлага нэмэгдсэнтэй холбоотой;
- Бараа материалын дансны үлдэгдэл 337,650.2 мянган төгрөг болж, 57,395.1 мянган буурсан нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 349,993.5 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 407,388.6 мянган төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаандаа зарцуулснаас шалтгаалжээ.
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 17,344,064.4 мянган төгрөг болж, 5,438,455.3 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 25,052.3 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн, Стандарт хэмжил зүйн газрын даргын 2025 оны А/223, 343, 302, 326, 298, 305, 247 дугаар тушаалуудаар улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтээр бэлтгэсэн нийт 1,642,135.5 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг хүлээн авч, барилга, байгууламжид хийсэн 1,207,229.7 мянган төгрөгийн урсгал засварыг капиталжуулж бүртгэсэн, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны А/2105 албан бичгээр Стандарт, хэмжил зүйн газраас 41,837.2 мянган төгрөгийн автомашиныг шилжүүлэн авсан, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны 283 дугаар тогтоолоор 7,545,283.0 мянган төгрөгийн үлдэх өртөггүй болсон хөрөнгийг 5,134,735.9 мянган төгрөгөөр үнийг шинэчлэн, бүртгэсэн боловч анхны хөрөнгөө үндсэн хөрөнгийн данснаас хасаагүй нь голлон нөлөөлжээ. Тайлант хугацаанд 2,612,535.3 мянган төгрөгийн элэгдлийг байгуулсан байна.
- Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 17,811,962.6 мянган төгрөг болж, 5,502,927.8 мянган төгрөгөөр өссөн нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны 283 дугаар тогтоолоор 7,545,283.0 мянган төгрөгийн үлдэх өртөггүй болсон хөрөнгийг 5,134,735.9 мянган төгрөгөөр үнийг шинэчлэн бүртгэхдээ хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү дансанд буруу бүртгэсэнтэй холбоотой, мөн тайлант хугацааны үр дүнгээс шалтгаалжээ.

Программ хангамжийн судалгааны талаар: Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторид 1,359.8 мянган төгрөгийн үнэ бүхий санхүү бүртгэлийн программ, 129,990.0 мянган төгрөгийн үнэ бүхий дээж бүртгэх, хариу олгох “Лимис” программ

ашиглагдаж байна. Тайлант онд “Лимис” программд нийт 19,500.0 мянган төгрөгийн хөгжүүлэлт хийгдсэн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага нь 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 10,622,060.1 мянган төгрөг, нийт зарлагыг 10,622,060.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг болон зарлагыг нийт 6,552,831.1 мянган төгрөгөөр бууруулж, 4,069,229.0 мянган төгрөгөөр баталжээ. Үүний шалтгаан нь төсвийн төслийг боловсруулахдаа өмнөх оны батлагдсан төсвөөс хөрөнгийн зардлыг 5,599,475.7 мянган төгрөг, нормативд зардлыг 872,274.3 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 81,089.1 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн санал хүргүүлсэн нь төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй төлөвлөхгүй байгаатай холбоотой байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,537,115.1 мянган төгрөгийг улсын төсвөөс, 1,500,00.0 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр тус тус баталжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,537,040.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, үйл ажиллагааны орлого 1,714,680.4 мянган төгрөг, нийт 4,251,720.7 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, 3,985,349.3 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэл 266,371.4 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,985,349.2 мянган төгрөг буюу 98.7 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлыг 50,845.8 мянган төгрөгөөр, лабораторын итгэмжлэлийн зардлыг 74.9 мянган төгрөгөөр, ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшууллын зардлыг 845.2 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган

төгрөгөөр/

Код	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
70407	Стандарт, хэмжил зүйн газар	4,037,115.1	3,985,349.2	51,765.9	98.7
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	3,958,515.9	3,907,670.1	50,845.8	98.7
80205	Мэдээлэл, сурталчилгааны зардал	20,000.0	20,000.0	-	100.0
80215	Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын зардал	19,800.0	19,800.0	-	100.0
80227	Лабораторийн итгэмжлэл	2,736.1	2,661.2	74.9	97.3
80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшууллын зардал	36,063.1	35,217.9	845.2	97.7

Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан “Төрийн аудитын байгууллагаас 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу шалгагдагч байгууллагаас 6 төрлийн судалгаа авч үр дүнг тайланд тусгасан. Үүнд:

1. Байгууллагын орон тооны цомхотгол: Хүнсний аюулгүй байдлын лавлагаа, лабораторийн батлагдсан орон тоог 2025 онд 111 байсныг 101 болгон бууруулж,

3,265,975.7 мянган төгрөгийн цалингийн зардал батлагдсаныг 3,111,387.5 мянган төгрөг болгож тодотгожээ.

2. Хүнсний аюулгүй байдлын лавлагаа, лабораторийн захирлын 2024 оны А/69 дугаар тушаалаар ажилчдын ажлын нэг өдрийн хоолны мөнгийг 19.0 мянган төгрөгөөр, унааны төлбөрийг 1.0 мянган төгрөгөөр баталжээ. Тайлант онд унаа хоолны хөнгөлөлтийн зардалд 472,393.5 мянган төгрөгийг төлөвлөснөөс 461,412.3 мянган төгрөгийг зарцуулж, 10,981.2 мянган төгрөгийг хэмнэсэн;
3. Гадаад томилолт, болон мэдээллийн зардалд төсөв батлагдаагүй, төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой гарсан зардал байхгүй болно.;
4. Тайлант хугацаанд хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх зардалд 2,300.0 мянган төгрөгийг баталснаас гүйцэтгэлээр 2,300.0 мянган төгрөгийг зарцуулсан;

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд Нэгдсэн үндэсний байгууллагын Хүнс, Хөдөө аж ахуйн газраас хандиваар 14,468.8 мянган төгрөг, үйл ажиллагааны төлбөр болох шинжилгээний орлого 2,625.0 мянган төгрөгийг, Ховд аймгийн эрүүл мэнийн газраас гэрээний урьдчилгаа төлбөр 19,433.0 мянган төгрөгийг, нийт нийт 36,526.8 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлсэн байна. Үүнээс ажилчин албан хаагчдад 10,400.0 мянган төгрөгийн шагнал урамшуулал, хангамж, материалын зардалд 2,512.4 мянган төгрөг, хоол хүнсний зардалд 1,500.1 мянган төгрөг, нийт 14,412.5 мянган төгрөгийг зарцуулж, 22,114.3 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд 174,257.8 мянган төгрөгийн эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгслийг 6 багц болгон худалдан авах ажиллаганы ерөнхий төлөвлөгөө баталж, холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж ажиллажээ.

Хүнсний аюулгүй байдлын лавлагаа, лабораторид тайлант онд худалдан авах ажиллагаатай холбоотой дараах зөрчил илэрсэн. Үүнд:

1. Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 02 тоот тогтоолын дагуу төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрэхгүйгээр 68,300.0 мянган төгрөгийн үнийн дүн бүхий гэрээг “Сэлэнгэ пресс” ХХК, “Дижитал медик” ХХК, “Борзон констракшн” ХХК-тай шууд худалдан авалтын нөхцлөөр харьцуулах үнийн саналгүйгээр хөрөнгө зарцуулсан;
2. Тайлант оны худалдан авах ажиллагааны батлагдсан төлөвлөгөөнөөс 47,464.0 мянган төгрөгийн илүү дүнгээр бараа материал шууд худалдан авсан нь байгууллагад төлөх өрийг нэмэгдүүлсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;"; 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;"; 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно.", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална." 35 дугаар зүйлийн 35.2-д "Гэрээ шууд байгуулах тухай зарлалыг бараа, ажил, үйлчилгээний ерөнхий мэдээллийн хамт цахим системд нийтэлж, энэ хуулийн 54.8-д зааснаар аж ахуй эрхлэгчид хэлэлцээ хийх урилга хүргүүлнэ", 44 дүгээр зүйлийн

44.1-т "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална.", гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийг мөрдөж ажиллаагүй зөрчлийг таслан зогсоох талаар албан шаардлага хүргүүллээ.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах орлогын төсөвлөлт, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үндсэн хөрөнгөтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Ариун төгс оршихуй аудит” ХХК-ийн аудитор Д.Сүхбаатар, Ч.Сэлэнгэ нар гүйцэтгэж, анхан шатны хяналтыг аудитын менежер С.Эрдэнэчимэг, захирал Г.Баялаг, Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Ж.Бүжинханд, аудитын менежер Б.Цогбаяр, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 10 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн үе шатанд гүйцэтгэлийн материаллаг байдлын түвшнийг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүн болох 4,451,051.8 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 44,510.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага ямар нэгэн тодорхой арга хэмжээ авч ажиллаагүй, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

Аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 29 горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж гүйцэтгэхэд зөрчил, дутагдал илрээгүй болно.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн нийт 115,764.0 мянган төгрөгийн 4 зөрчлөөс 115,764.0 мянган төгрөгийн 2 зөрчилд 2 албан шаардлага, 2 зөрчилд 2 зөвлөмж өглөө.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори нь Шилэн дансны цахим хуудаст ил тод байршуулах 171 мэдээлэл оруулахаас 166 мэдээллийг хугацаанд нь, 1 мэдээлэл хугацаа хоцроосон, мэдээлээгүй 5 мэдээлэл байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", Засгийн газрын 2016 оны "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын 2.2.1.2-д "санхүүгийн тайлан", 2.2.1.6-д "төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, тайлбарын хамт", 2.2.3.6-д "аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах талаар зөвлөмж өгсөн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай холбогдох шалгууртай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1.Тайлант онд үндсэн үйл ажиллагааны орлогыг 1,500,000.0 мянган төгрөгөөр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 1,700,947.4 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 13.4 хувиар давуулан биелүүлсэн нь үйл ажиллагааны орлогыг үндэслэлтэй төлөвлөхгүй байгааг илэрхийлж байна.

Энэ нь "Төсвийн тухай" хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.", 6.2.2-т "жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх; 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;", "Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах хяналт тавих журам"-ын 1.6-д "Төсвийн ерөнхийлөн захирагч харьяа төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг бодитой тооцож төсөвт тусгуулах ба хэрэв үндэслэлгүй төлөвлөгөө батлуулсан нь нотлогдвол энэ журамд заасан зарцуулах эрх олгохгүй" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Орлогын төлөвлөгөөг бодитой тооцож, өмнөх онуудын гүйцэтгэлтэй харьцуулах, инцляцийн түвшинтэй уялдуулах, үйл ажиллагаанд нөлөөлөх бусад гадаад дотоод орчны нөлөө зэргийг харгалзан үзэж үндэслэлтэй төлөвлөж, гүйцэтгэлийг хангах талаар зөвлөмж өгсөн.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа, лабораторийн 2025 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайланд завсрын аудитыг хийж, мөнгөн хөрөнгө, бараа материал, орлогын данстын хувьд горим, сорил хэрэгжүүлсэн.

Аудитын илрүүлэлтийг шалгагдагч байгууллагад танилцуулж, асуудлын бүртгэлээр баталгаажуулсан. Завсрын аудитаар 104,603.1 мянган төгрөгийн 6 зөвлөмжийг хүргүүлсэн бөгөөд санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмжийн хэрэгжилтийг давтан үнэлж хэрэгжүүлээгүй 3 асуудалд дараагийн шатны шийдвэр өгч аудитын тайланд тусгасан.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон 7,151.8 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, зөрчлийг арилгах 604,462.6 мянган төгрөгийн 4 албан шаардлага, 8,320.5 мянган төгрөгийн 3 зөвлөмжийг өгснийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган

төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	3	7,151.8	3	7,151.8	100.0
Албан шаардлага	4	604,462.6	4	604,462.6	100.0
Зөвлөмж	3	8,320.5	3	8,320.5	100.0
Нийт дүн	10	619,934.9	10	619,934.9	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн дараагийн аудитаар санхүүгийн тайлагнал, нягтлан бодох бүртгэл, орлогын программ болон санхүүгийн тайлагналын уялдаа холбоо, худалдан авах ажиллагаа, өмнөх аудитын шийдвэрийн хэрэгжилтийг үзэхээр байна. Эрсдэлийн үнэлгээ хийлгэхээр “Эс Эс Ай Эм Эн” ХХК-тай байгуулсан 8,000.0 мянган төгрөгийн гэрээний биелэлт, үйл ажиллагааны тайлан ирүүлсэн эсэхийг нягтлан үзэх болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 16,460,217.6 мянган төгрөгийн 11 алдаа¹ илэрснээс аудитын явцад 3,440,943.6 мянган төгрөгийн 7 алдааг залруулж, 13,019,274.0 мянган төгрөгийн 4 алдааг арилгах албан шаардлага хүргүүлээ.

Залруулсан алдаа:

1. Санхүүгийн байдлын тайлангийн богино хугацаат өр төлбөрийг өглөгийн тодруулга тайлангийн дүнгээс 3,150.5 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан;
2. Санхүүгийн байдлын тайланд 234,113.4 мянган төгрөгийн татаас санхүүжилтийн авлагыг байгууллагаас авах авлагаар тайлагнасан;
3. Нэмэлт санхүүжилтийн тайланг үнэн зөв тайлагнаагүй, нийт цэвэр мөнгөн гүйлгээг 14,412.5 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн;
4. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн А-1/2105 албан бичгээр Стандарт, хэмжил зүйн газраас шилжиж ирсэн 41,837.3 мянган төгрөгийн дансны үнэ бүхий автомашиныг машин тоног төхөөрөмжийн дансанд ангилалд буруу бүртгэсэн;
5. Нэмэлт санхүүжилтийн данснаас татан төвлөрүүлсэн 22,114.2 мянган төгрөгийг үндсэн дансны төвлөрүүлэх шилжүүлэг дансаар тайлагнасан;
6. Тайлант хугацаанд авлагаар тайлагнасан 234,113.4 мянган төгрөгийн төвлөрүүлэх шилжүүлгийг бүртгэхдээ үр дүнгийн тайлангийн нэмэлт санхүүжилтийн орлогын төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогыг нэмэгдүүлж буруу тайлагнасан;
7. Үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй хүлээн авсан 2,891,202.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-үндсэн хөрөнгө дансаар тайлагнаагүйг аудитаар тус тус залруулга хийлгэсэн.

Эдгээр алдаанууд нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-д "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т "Энэ хуулийн 4.4-т заасан байгууллага нь Төсвийн тухай хуулийн 26.3-т нийцүүлэн нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасантай тус тус нийцэхгүй, УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулгын 1.27, УСНББОУС-17 Үндсэн хөрөнгийн 17.42 дахь параграф болон санхүүгийн аудитын "Оршин байх", "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Залруулаагүй алдаа:

1. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны 283 дугаар тогтоолын дагуу анхны өртгөө нөхсөн 427 нэр төрлийн 7,545,283.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг данснаас хасаагүй;
2. Ашиглалтын хугацааг сунгаж дансны үнийг шинэчлэн тогтоосон 5,134,736.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг орлого авахдаа "Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү" дансанд буруу бүртгэж тайлагнасан;
3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтээр барилга байгууламжид хийгдсэн нийт 1,489,912.9 мянган төгрөгийн их засварын ажлыг капиталжуулахдаа 282,683.2 мянган төгрөгөөр дутуу бүртгэсэн;
4. Үндсэн хөрөнгийн бүртгэлд 56,571.8 мянган төгрөгийн өртөг бүхий 17 нэр төрлийн 32 хөрөнгөнд тайлант хугацаанд элэгдлийн зардлыг тооцоогүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө", 14 дүгээр зүйлийн 14.4-т

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

"Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.5-т "бүх орлого", 14.4.6-д "бүх зардал", 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй, УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулгын 1.27, УСНББОУС-17 Үндсэн хөрөнгийн 17.42 дахь параграф болон Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын 10.6-д "Хөрөнгө хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангаж, үндсэн хөрөнгийн тодорхойлолтод нийцсэн бөгөөд байгууллагын хэрэгцээнд ашиглах, бусдад түрээслүүлэх зорилгоор эзэмшиж байгаа хөрөнгийг үндсэн хөрөнгөөр хүлээн зөвшөөрч, бүртгэнэ", 10.15-д "Үндсэн хөрөнгийг хүлээн зөвшөөрсний дараа өртгийн ба дахин үнэлгээний загварын аль нэгээр үнэлж, санхүүгийн тайланд толилуулна. (а) өртгийн загвар нь хөрөнгийг хүлээн зөвшөөрсний дараа түүний анхны өртгөөс хуримтлагдсан элэгдэл ба хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын гарзыг хассан дүнгээр бүртгэнэ. (б) дахин үнэлгээний загвар нь дахин үнэлгээний өдрөөрх хөрөнгийн бодит үнэ цэнээс дараагийн тайлант үеийн аливаа хуримтлагдсан элэгдэл ба дараагийн тайлант үеийн хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын гарзыг хассан дүнгээр бүртгэнэ", 10.19-д "Төсвийн байгууллага нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 2 дахь заалтын дагуу Засгийн газраас гаргасан эд хөрөнгийг дахин үнэлэх тухай шийдвэрийг, эсхүл Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т заасан эрх бүхий этгээдийн шийдвэрийг тус тус үндэслэн үндсэн хөрөнгийн дахин үнэлгээг хийнэ" гэж тус тус заасныг тус тус хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайлангийн дансны үлдэгдэл, тодруулгыг алдаатай илэрхийлсэн алдааг арилгах албан шаардлага хүргүүлэв.

Аудитаар нийт 654,037.9 мянган төгрөгийн залруулаагүй алдаа, зөрчил² илэрснээс, 9,398.7 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 351,712.0 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 292,927.2 мянган төгрөгийн зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 13,673,311.9 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 13,628,801.4 мянган төгрөгөөр давсан тул Хязгаарлалттай дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

1. Тайлант онд нэр бүхий 21 ажилтанд 9,398.7 мянган төгрөгийн цалинг зөрүүтэй тооцож олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3-т "батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Ажилтнуудад цалинг зөрүүтэй олгосон нийт 9,398.7 мянган төгрөгийг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

1. Тайлант хугацаанд харилцагч байгууллагуудаас авах нийт 19,503.1 мянган төгрөгийн авлагын, бэлтгэн нийлүүлэгч байгууллагад төлөх 89,760.3 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудтай өглөг, авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулах талаар албан шаардлага хүргүүлэв.

2. Бараа материалын дансанд тайлант онд огт хөдөлгөөн ороогүй нийт 59,653.7 мянган төгрөгийн үнийн дүнтэй 281 нэр төрлийн 643 ширхэг эм урвалжийн материалын нөөцтэй үлдэгдэлтэй хэвээр байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-д "нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөхийг хориглоно" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн хөрөнгөөр шаардлагагүйгээр их хэмжээний бараа материал бэлтгэж, нөөцөлдөг зөрчлийг таслан зогсоох талаар албан шаардлага хүргүүлэв.

3. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үндсэн үйл ажиллагааны орлогын дүн нь сорьцын шинжилгээний "Лимис" программын орлогын дүнгээс 182,794.9 мянган төгрөгөөр илүү тусгагдсан байна. Энэ нь уг программд анхдагч мэдээллийг оруулдаг дээж хүлээн авах хэсэг болон санхүү бүртгэлийн хэлтэс хоорондын ажлын уялдаа холбоо, түүнд тавих дотоод хяналт хангалтгүй байгаатай холбоотой байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5-д "Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:" 16.5.7-т "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", 26 дугаар зүйлийн 26.1-т "Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккрузал суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө.", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлнө", 6.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузал сууриар хөтөлнө.", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Үндсэн үйл ажиллагааны орлогын дүнг сорьцын шинжилгээний "Лимис" программын орлогын дүнгээс зөрүүтэй тайлагнасан зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1.Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт 1: Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 292,927.2 мянган төгрөгийн 56 нэр төрлийн, 254 ширхэг хөрөнгө бүртгэлтэй байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 271 дугаар тогтоолоор баталсан Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журмын 7.1-т "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг

нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэж, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлж, шийдвэрлүүлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

№	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Албан шаардлага	
								Залруулсан		Залруулаагүй			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Санхүүгийн байдлын тайлангийн богино хугацаат өр төлбөрийг өглөгийн тодруулгаас 3,150.5 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан.	1	3,150.5			1	3,150.5	1	3,150.5				
2	Санхүүгийн байдлын тайланд 234,113.4 мянган төгрөгийн татаас санхүүжилтийн авлагыг байгууллагаас авах авлагаар тайлагнасан.	1	234,113.4			1	234,113.4	1	234,113.4				
3	Нэмэлт санхүүжилтийн тайланг үнэн зөв тайлагнаагүй, нийт цэвэр мөнгөн гүйлгээг 14,412.5 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн.	1	14,412.5			1	14,412.5	1	14,412.5				
4	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025.10.30-ны өдрийн А-1/2105 албан бичгээр Стандарт, хэмжил зүйн газраас шилжиж ирсэн 41,837.3 мянган төгрөгийн дансны үнэ бүхий автомашиныг машин тоног төхөөрөмжийн дансанд ангилалд буруу бүртгэсэн.	1	41,837.3			1	41,837.3	1	41,837.3				
5	Нэмэлт санхүүжилтийн данснаас татан төвлөрүүлсэн 22,114.2 мянган төгрөгийг үндсэн дансны төвлөрүүлэх шилжүүлэг /213303/ дансаар тайлагнасан.	1	22,114.2			1	22,114.2	1	22,114.2				
6	Тайлант хугацаанд авлагаар тайлагнасан 234,113.4 мянган төгрөгийн төвлөрүүлэх шилжүүлгийг бүртгэхдээ үр дүнгийн тайлангийн нэмэлт санхүүжилтийн орлогын төсвийн байгууллагын үндсэн үйл	1	214,680.4			1	234,113.4	1	234,113.4				

/мянган төгрөгөөр/

	ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогыг нэмэгдүүлж буруу тайлагнасан.												
7	Үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй хүлээн авсан 2,891,202.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-үндсэн хөрөнгөөр /1200017/ тайлагнаагүй.	1	2,891,202.3			1	2,891,202.3	1	2,891,202.3				
8	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны 283 дугаар тогтоолоор дансны үнийг нь шинэчлэн тогтоож, ашиглалтын хугацааг сунгасан 427 нэр төрлийн анхны өртөг бүхий 7,545,283.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг данснаас хасалт хийгээгүй.	1	7,545,283.0							1	7,545,283.0	1	7,545,283.0
9	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны 283 дугаар тогтоолоор дансны үнийг шинэчлэн тогтоож, ашиглалтын хугацааг сунгасан 5,134,736.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг орлого авахдаа "Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү" дансанд буруу бүртгэж тайлагнасан.	1	5,134,736.0							1	5,134,736.0	1	5,134,736.0
10	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар барилга байгууламжид хийгдсэн нийт 1,489,912.9 мянган төгрөгийн их засварын ажлыг капиталжуулахдаа 282,683.2 мянган төгрөгөөр дутуу бүртгэсэн.	1	282,683.2							1	282,683.2	1	282,683.2
11	Үндсэн хөрөнгийн бүртгэлд 56,571.8 мянган төгрөгийн өртөг бүхий 17 нэр төрлийн 32 хөрөнгөнд тайлант хугацаанд элэгдлийн зардлыг тооцоогүй.	1	56,571.8							1	56,571.8	1	56,571.8
	Дүн	11	16,460,217.6	-	-	7	3,440,943.6	7	3,440,943.6	4	13,019,274.0	4	13,019,274.0

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс								Хууль, хяналтын байгууллагад шилжүүлэх асуудал	
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Харилцагч байгууллагуудаас авах нийт 19,503.1 мянган төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй.	1	19,503.1			1	19,503.1						
2	Бараа материалын бүртгэлд оны эхнээс огт хөдөлгөөн ороогүй 281 нэр төрлийн 643 ширхэг эм урвалжийн материалын нөөцтэй байна.	1	59,653.7			1	59,653.7						
3	Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 292,927.2 мянган төгрөгийн анхны өртөгтэй, 56 нэр төрлийн, 254 ширхэг хөрөнгө бүртгэлтэй байна.	1	292,927.2					1	292,927.2				
4	Харилцагч байгууллагад өгөх өрийн 89,760.3 мянган төгрөгийн үлдэгдэлд тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй.	1	89,760.3			1	89,760.3						
5	Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үндсэн үйл ажиллагааны орлогын дүн нь сорцын шинжилгээний "Лимис" программын орлогын дүнгээс 182,794.9 мянган төгрөгөөр илүү тусгагдсан нь уг программ хангамжийн бүртгэлд санхүүгийн ажилтнуудаас дотоод хяналт хангамжгүй байгаатай холбоотой байна.	1	182,794.9			1	182,794.9						
6	Нэр бүхий 26 ажилтанд 9,398.7 мянган төгрөгийн цалин илүү болон дутуу тооцож олгосон.	1	9,398.7	1	9,398.7								
	Дүн	6	654,037.9	1	9,398.7	4	351,712.0	1.0	292,927.2	-	-	-	

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
				Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил							
1	Шилэн дансны цахим хуудаст ил тод байршуулах 171 мэдээлэл оруулвал зохистойгоос 166 мэдээллийг хугацаанд нь, 1 мэдээлэл хугацаа хоцроосон, хугацаагүй нь болоогүй 5 мэдээлэл байна.	1	-	-	-	1	-
	Дүн	1	-	-	-	1	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил							
1	Засгийн газраас тогтоосон босго үнээс бага үнийн дүн бүхий гэрээг нэр бүхий 4 компанитай 68,300.0 мянган төгрөгийг шууд худалдан авалтын нөхцлөөр харьцуулах үнийн саналгүйгээр зарцуулсан.	1	68,300.0	1	68,300.0	-	-
2	Худалдан авах ажиллагааны жилийн төлөвлөгөөнөөс 47,464.0 мянган төгрөгийн илүү бараа материал худалдан авсан. Үүнтэй холбоотой байгууллагад төлөх өрийн өсөлт бий болсон.	1	47,464.0	1	47,464.0	-	-
3	Үндсэн үйл ажиллагааны орлогыг үндэслэлтэй төсөвлөөгүй. Төлөвлөсөн орлого 1,500,000.0 мянган төгрөг, гүйцэтгэлээрх орлого 1,700,947.4 мянган төгрөг байна. Орлогыг 13.4 хувиар давуулан биелүүлсэн.	1	-	-	-	1	-
	Дүн	3	115,764.0	2	115,764.0	1	0
	Нийт дүн	4	115,764.0	2	115,764.0	2	0



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 71/А0150169

Улаанбаатар хот

САГ-2026/280/НА-СТА-ТШЗ

Зөрчлийг таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Бараа материалын дансанд оны эхнээс огт хөдөлгөөн ороогүй 59,653,712.95 (Тавин есөн сая зургаан зуун тавин гурван мянга долоон зуун арван хоёр төгрөг ерэн таван мөнгө) төгрөгийн үнийн дүнтэй 281 нэр төрлийн 643 ширхэг эм урвалжийн материалын нөөцтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-д "нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөхийг хориглоно" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.4-т "төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, зах зээлийн үнээс өндөр үнэтэй эсвэл шаардлагагүй хөрөнгө олж бэлтгэсэн;" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийн хөрөнгөөр шаардлагагүйгээр их хэмжээний бараа материал бэлтгэж, нөөцөлдөг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн захирал /Б.Дөлгөөн/, ерөнхий нягтлан бодогч /Х.Отгонтуяа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН :

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
"АРИУН ТӨГС ОРШИХУЙ АУДИТ"
ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
А.ЦОГБАЯР

Г.БАЯЛАГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

9025081411

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-7.Docx

1526180241



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 70/АД150169

Улаанбаатар хот

САГ-2026/280/НА-СТА-ТШЗ

Зөрчлийг арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд харилцагч байгууллагуудаас авах нийт 19,503,073.13 (Арван есөн сая таван зуун гурван мянга далан гурван төгрөг арван гурван мөнгө) төгрөгийн авлагын, бэлтгэн нийлүүлэгч байгууллагад өгөх 89,760,250.74 (наян есөн сая долоон зуун жаран төгрөг хоёр зуун тавин мянган төгрөг далан дөрвөн мөнгө) төгрөгийн өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах," гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.7-т "авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй," гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудтай өглөг, авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 12⁰⁰ дугаар сарын 01-ны өдрийн Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн захирал /Б.Дөлгөөн/, Ерөнхий нягтлан бодогч /Х.Отгонтуяа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН :

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
"АРИУН ТӨГС ОРШИХУЙ АУДИТ"
ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
А.ЦОГБАЯР

Г.БАЯЛАГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тосго-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-7.Docx

1526180243



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 10/A0150169

Улаанбаатар хот

САГ - 2026/280/НА - СТА - ТЦЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд хавсралтад дурдсан нэр бүхий 21 ажилтанд нийт 9,398,676.00 (Есөн сая гурван зуун ерэн найман мянга зургаан зуун далан зургаан) төгрөгийн цалинг зөрүүтэй тооцож олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3-д "батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох"; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.3-д "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн хавсралтад дурдсан 21 ажилчдад зөрүүтэй олгосон нийт 9,398,676.00 (Есөн сая гурван зуун ерэн найман мянга зургаан зуун далан зургаан) төгрөгийг буруутай албан тушаалтан Ерөнхий нягтлан бодогч Х.Отгонтуяа, Хүний нөөцийн ажилтан Г.Санчир, тооцооны нягтлан бодогч Д.Анар нараар төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сангийн Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн захирал /Б.Дөлгөөн/ хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
"АРИУН ТӨГС ОРШИХУЙ АУДИТ"
ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
А.ЦОГБАЯР

Г.БАЯЛАГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

Z:\Акт\2026\0225 SAG-5.Docx

1526200037



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 69/АД/50169

Улаанбаатар хот

САГ-2026/280/НА-СТА-ТШЗ

Зөрчлийг арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үндсэн үйл ажиллагааны орлогын дүн нь сорьцын шинжилгээний "Лимис" программын орлогын дүнгээс 182,794,940.30 (Нэг зуун наян хоёр сая долоон зуун ерэн дөрвөн мянга есөн зуун дөчин төгрөг гучин мөнгө) төгрөгөөр илүү тусгагдсан байна. Энэ нь уг программд анхдагч мэдээллийг оруулдаг дээж хүлээн авах хэсэг болон санхүү бүртгэлийн хэлтэс хоорондын ажлын уялдаа холбоо болон түүнд тавих дотоод хяналт хангалтгүй байгаатай холбоотой байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5-д "Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:" 16.5.7-т "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", 26 дугаар зүйлийн 26.1-т "Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккруэл суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө.", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлнө", 6.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө.", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-д "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй," гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Сорьцын шинжилгээний "Лимис" программын орлогын дүн болон үндсэн үйл ажиллагааны орлогын дүнгийн зөрүүтэй байгаа зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн захирал /Б.Дөлгөөн/, ахлах нягтлан бодогч /Х.Отгонтуяа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН :
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР А.ЦОГБАЯР
“АРИУН ТӨГС ОРШИХУЙ АУДИТ”  Г.БАЯЛАГ
ХХК-ИЙН ЗАХИРАЛ





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 67/АД150169

Улаанбаатар хот

САГ - 2026/280/НА - СТА - ТШЗ

Зөрчлийг таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар илэрлээ. Үүнд:

1. Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 02 тоот тогтоолын дагуу төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрэхгүйгээр 68,300,000.00 (Жаран найман сая гурван зуун мянган) төгрөгийн үнийн дүн бүхий гэрээг Сэлэнгэ пресс ХХК, Дижитал медик ХХК, Борзон констракшн ХХК, нэр бүхий 3 компанитай шууд худалдан авалтын нөхцөлөөр харьцуулах үнийн саналгүйгээр хөрөнгө зарцуулсан;
2. Тайлант оны батлагдсан худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнөөс 47,463,950.00 (Дөчин долоон сая дөрвөн зуун жаран гурван мянга есөн зуун тавин) төгрөг хэтрүүлж бараа материал худалдан авсан. Энэ нь жилийн эцсээрх байгууллагад төлөх өрийг нэмэгдүүлсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх"; 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"; 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно.", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална." 35 дугаар зүйлийн 35.2-д "Гэрээ шууд байгуулах тухай зарлалыг бараа, ажил, үйлчилгээний ерөнхий мэдээллийн хамт цахим системд нийтэлж, энэ хуулийн 54.8-д зааснаар аж ахуй эрхлэгчид хэлэлцээ хийх урилга хүргүүлнэ", 44 дүгээр зүйлийн 44.1-т "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална.", гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.9-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийг мөрдөж ажиллаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн захирал /Б.Дөлгөөн/, ахлах нягтлан бодогч /Х.Отгонтуяа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН :
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
“АРИУН ТӨГС ОРШИХУЙ АУДИТ”
ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
А.ЦОГБАЯР
Г.БАЯЛАГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 68/A0150169

Улаанбаатар хот

САГ-2026/280/НА-СТА-ТШЗ

Зөрчлийг арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны 283 дугаар тогтоолын дагуу анхны өртгөө нөхсөн 427 нэр төрлийн 7,545,283,025.26 (долоон тэрбум таван зуун дөчин таван сая хоёр зуун наян гурван мянга хорин таван төгрөг жаран зургаан мөнгө) төгрөгийн үндсэн хөрөнгийг данснаас хасаагүй, ашиглалтын хугацааг сунгаж дансны үнийг шинэчлэн тогтоосон 5,134,735,976.33 (таван тэрбум нэг зуун гучин дөрвөн сая долоон зуун гучин таван мянга есөн зуун далан зургаан төгрөг гучин гурван мөнгө) төгрөгийн үндсэн хөрөнгийг орлого авахдаа "Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү" дансанд буруу бүртгэж тайлагнасан;
2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтээр барилга байгууламжид хийгдсэн нийт 1,489,912,956.60 (нэг тэрбум дөрвөн зуун наян есөн сая есөн зуун арван хоёр мянга есөн зуун тавин зургаан төгрөг жаран мөнгө) төгрөгийн их засварын ажлыг капиталжуулахдаа 282,683,239.60 (хоёр зуун наян хоёр сая зургаан зуун наян гурван мянга хоёр зуун гучин есөн төгрөг жаран мөнгө) төгрөгөөр дутуу бүртгэсэн;
3. Үндсэн хөрөнгийн бүртгэлд 56,571,746.80 (тавин зургаан сая таван зуун далан нэгэн мянга долоон зуун дөчин зургаан төгрөг наян мөнгө) төгрөгийн өртөг бүхий 17 нэр төрлийн 32 хөрөнгөнд тайлант хугацаанд элэгдлийн зардлыг тооцоогүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө", 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.5-т "бүх орлого", 14.4.6-д "бүх зардал", 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй, Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын 10.6 "Хөрөнгө хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангаж, үндсэн хөрөнгийн тодорхойлолтод нийцсэн бөгөөд байгууллагын хэрэгцээнд ашиглах, бусдад түрээслүүлэх зорилгоор эзэмшиж байгаа хөрөнгийг үндсэн хөрөнгөөр хүлээн зөвшөөрч, бүртгэнэ", 10.15 "Үндсэн хөрөнгийг хүлээн зөвшөөрсний дараа өртгийн ба дахин үнэлгээний загварын аль нэгээр үнэлж, санхүүгийн тайланд толилуулна. (а) өртгийн загвар нь хөрөнгийг хүлээн зөвшөөрсний дараа түүний анхны өртгөөс хуримтлагдсан элэгдэл ба хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын гарзыг хассан дүнгээр бүртгэнэ. (б) дахин үнэлгээний загвар нь дахин үнэлгээний өдрөөрх хөрөнгийн бодит үнэ цэнээс дараагийн тайлант үеийн аливаа хуримтлагдсан элэгдэл ба дараагийн тайлант үеийн хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-7.Docx

1526180186

гарзыг хассан дүнгээр бүртгэнэ”, 10.19 “Төсвийн байгууллага нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 2 дахь заалтын дагуу Засгийн газраас гаргасан эд хөрөнгийг дахин үнэлэх тухай шийдвэрийг, эсхүл Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т заасан эрх бүхий этгээдийн шийдвэрийг тус тус үндэслэн үндсэн хөрөнгийн дахин үнэлгээг хийнэ” гэж тус тус заасныг хэрэгжүүлээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.1-д “нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Санхүүгийн тайлангийн ажил гүйлгээний анги, дансны үлдэгдэл, тодруулгыг алдаатай илэрхийлсэн зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн захирал /Б.Дөлгөөн/, ерөнхий нягтлан бодогч /Х.Отгонтуяа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
“АРИУН ТӨГС ОРШИХҮЙ АУДИТ”
ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
А.ЦОГБАЯР

Г.БАЯЛАГ

